



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2017 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 6/91

Чингис хот

Сахилгын шийтгэл оногдуулах тухай

Төрийн албаны тухай Монгол улсын хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалт, Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.2 дахь заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам /код-136/”-ын 136.4.2-ын “а” заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар батлагдсан “Сахилгын шийтгэл оногдуулах журам /код-914/”-ын 914.3.1 дэх заалт, цагдаагийн газрын даргын зөвлөлийн 2017 оны 08 дугаар сарын 07-ний өдрийн ээлжит 14 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах ахлагч Л.Эрдэнэтуул нь өндөржүүлсэн бэлэн байдлын нэгдүгээр зэрэглэлд шилжүүлэн ажиллах үед ажлын байранд дүрэмт хувцастай архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн, ажлын байрны тодорхойлолтонд заагдсан үндсэн ажлаа хангалтгүй хэрэгжүүлж, Төрийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэхь заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-ийн 12 дугаар зүйлийн 12.9 дэхь заалтыг тус тус зөрчсөн байх тул албан тушаалын цалинг 3 сар хүртэл хугацаатай 20.0 хувь бууруулах сахилгын шийтгэл оногдуулсугай.

2. Сахилгын зөрчил дутагдал гаргасан цагдаагийн ахлах ахлагч Л.Эрдэнэтуулыг дахин зөрчил дутагдал гаргахгүй байх чиглэлээр баталгаа авч, Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.7 дахь заалтыг үндэслэн төлбөртэй сургалтанд хамруулж, холбогдох хууль, дүрэм, журмуудыг өөрсдөөр нь судлуулах, үр дүнг тооцох, хариуцсан алба хаагч нартаа бүртгэлээр тавих хяналт, шалгалтыг тогтмолжуулахыг Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Баярсайханд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын

4. Тушаалын хуулбарыг хувийн хэрэгт нь хавсаргахыг Хүний нөөцийн мэргэжилтэн, цагдаагийн ахмад П.Алтантуяад үүрэг болгосугай.

5. Тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА Ж.БОЛД

